**НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХАВСРАЛТ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хэрэгжилтийн хугацаа удааширсан, зээлийн үр ашиг, үндсэн зээл болон зээлийн хүүд ямар хэмжээний төлбөр төлсөн тухай, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир бага хүүтэй зээлийн хэлэлцээрийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, 2017 оноос хойш төслийн хэрэгжилт удааширсан шалтгаан, Орхон аймагт хэрэгжүүлж буй хатуу хог боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл болон төсөлд аудитын дүгнэлт хийгдсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл улсын хэмжээнд гадаадын зээл тусламжаар нийт хичнээн төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа тухай Байнгын хорооны хуралдаанаар мэдээлэл сонсох, үр ашиггүй, хэрэгжээгүй төсөл, хөтөлбөрт ажиллаж байсан ажилтнуудад хариуцлага тооцсон эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл гадаад зээлийн үр ашгийг тооцох, хэрэгжилтэд хяналт тавихад Сангийн яам анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат зээлийн ерөнхий хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг дэмжиж байгаа бөгөөд цаашид орон нутагт хэрэгжүүлэх бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих асуудлыг 330 сумдад болон говийн бүсийн аймгуудад хэрэгжүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нэн хөнгөлөлттэй, бага хүүтэй зээлийн хэрэгжилт үр дүнтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Сангийн яамнаас гадаадын зээл тусламжаар нийт хичнээн төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа болон ямар хэмжээний төлбөр төлж байгаа тухай, хэлэлцээрийн төсөвт өртөг, үр ашгийн талаарх тооцоолол мэдээллийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар сонсох талаар үг хэлсэн болно.

Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,**
**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ** **С.ЛҮНДЭГ**

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

## НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХАВСРАЛТ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**~~Улаанбаатар хотноо~~ Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг